

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН ЧАДАВХИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Чойжилын Энхбаяр, доктор (Ph.D), профессор, Бизнесийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Надмидын Батжаргал, докторант, ахлах багш, Бизнесийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

XXI зууны дэлхийн хөгжлийн хандлага төвлөрлийг сааруулах, муж орон нутгийн хөгжил, санхүүгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэх болсон. Үүнтэй холбоотой дэлхийн улс орнууд муж, орон нутгийнхаа санхүүгийн бие даасан байдлыг хангах орлогыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж байна. ХХОАТ-ын өөрчлөлт, шинэчлэлийн хандлагыг олон улсын болон Монголын түвшинд судалж, улмаар уг татварын орон нутгийн санхүүгийн чадавхад үзүүлэх нөлөөг тодорхойлох зорилго тавьсан болно. ХХОАТ-ын өөрчлөлт, шинэчлэлийн олон улсын хандлагаас тухайн улсын хөгжлийн түвшинг тодорхойлох боломжтой. Хөгжингүй орнуудад ХХОАТ-ын их орлоготой бол ихийг төлөх зарчим үйлчилж байгаа бол хөгжиж байгаа улс орнуудын хувьд ХХОАТ-ын хувь хэмжээг бууруулж, шатлалыг багасгаж байна. Харин ХХОАТ-ын хувь хэмжээг тивээр авч үзвэл, хамгийн өндөр нь Африк, Америк тивийн улсууд байгаа бол хамгийн бага нь буюу татвар ногдуулдаггүй улсын 7 нь Ази тивд, 3 нь Америк тивд байна.

Манай улсын хувьд 2006 онд бодлогын чанартай, томоохон шинэчлэл хийгдсэн бөгөөд хувь хүний жилийн орлогод 15-30 хүртэл өсөн нэмэгдэх шатлалаар ногдуулж байсан татварын хувь хэмжээг 10 хувиар тогтоосон нь татварын бааз суурийг өргөтгөх чухал алхам болсон. Тиймээс орон нутгийн татварын орлогын 60 орчим хувийг бүрдүүлж байгаа ХХОАТ-ын орон нутгийн санхүүгийн бие даасан байдал буюу санхүүгийн чадавхид үзүүлэх нөлөөг судалж үзсэн болно.

Түлхүүр үгс: Хувь хүний орлогын албан татвар, Орон нутгийн санхүүгийн чадавхи, Орон нутгийн төсвийн орлого, татварын шинэчлэл

Abstract

World development attitude of 21st century is focusing on the decentralization, development and financial capacity of state or region. According to this, countries are more emphasizing on providing state or region with financial independence and increasing the income. Examining the changes and updates of PIT in International and Mongolian level is our aim. We are targeting to identify its impact on local financial capacity. The country's development level is possible to be identified by International altitude of changes and updates in PIT. "Pay As You Earn" or earn more and pay more principle is the main PIT principle of developed countries, while developing countries are reducing the rate of PIT and the gradient. Examining the rate of PIT by continent, Africa and America have the highest, whereas minimum or no tax added countries are including 7 Asian countries and 3 American countries.

In 2006, some major changes were made in Mongolia and one of them was relating to PIT. We made an essential step to expand the tax base by reducing it into 10 percent, whereas it was 15-30 percent with increasing gradients. Thus, the research has been done to examine the impact of PIT, which is compounding around 60 percent of local tax income, on financial independence of region or its financial capacity.

Keywords: Personal income tax, Local financial capacity, Local budget revenue, Tax reform

1. Оршил

Татварын тогтолцооны шинэчлэл нь эдийн засгийн өсөлтийг хангах, засаглалыг сайжруулах бололцоог олгодог. Аль ч улсын хувьд Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын суурийг өргөтгөх нь капиталын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой (Cottarelli, 2011). ХХОАТ-ын шинэчлэл, өөрчлөлт нь өндөр орлоготой хүмүүсийн татвараас зайлсхийх боломжийг багасгаснаар илүү үр дүнтэй татвар ногдуулах, орлого төвлөрүүлэх нөхцөлийг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм. ХХОАТ-ын хувь хэмжээ, түүний шинэчлэлийн бодлого зэрэг нь тухайн улсын хөгжлийн түвшнээс хамаарч, ялгаатай байдгийг олон тооны судалгаа нотлож байна.

Онолын хувьд ХХОАТ-ын оновчтой түвшин нь хөрөнгө оруулалт, хүмүүн капитал, инновацийн үр ашиг болон урт хугацааны өсөлтөд нөлөөтэй гэж үздэг. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудыг жишээ болговол энд хөрөнгийн татвар эдийн засгийн өсөлтөд хамгийн бага, харин хэрэглээний татвар, ХХОАТ болон аж ахуйн

нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) хөрөнгө оруулалтын өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлж байна (Arnold, 2008). Түүнчлэн аливаа татвар, түүнээс орох орлого нь төрийн санхүүгийн чадавхыг тодорхойлох гол үзүүлэлт болдог ажээ. Төрийн санхүүгийн чадавх, санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлох нэг гол үзүүлэлт нь татварын орлого тул орон нутгийн төсвийн орлогын үндсэн эх үүсвэр болсон ХХОАТ, түүний орон нутгийн санхүүгийн чадавхад үзүүлэх нөлөөг тодорхойлох нь олон талын ач холбогдолтой.

Манай улсын хувьд ХХОАТ-ын орлого тухайн орон нутгийнхаа санхүүгийн чадавхад маш хүчтэй нөлөөлж байгааг судалгааны дүн харуулж байна. Харин олон улсын хандлага ямар байгааг эхлээд авч үзье.

2. ХХОАТ-ын шинэчлэлийн өнөөгийн байдал, олон улсын хандлага

ХХОАТ-ын хувь хэмжээгээр улс орны хөгжлийн түвшинг тодорхойлж болно. Гэхдээ бусад үзүүлэлт, шалгуурыг бас бодолцож үзэх нь чухал. Хөгжингүй орнуудад шууд татварын, тэр дундаа хувь хүний орлогод ногдуулах татварын хувь хэмжээ харьцангуй өндөр байдгийг Хүснэгт 2.1-с харж болно.

Хүснэгт 2.1: Улс орнуудын ХХОАТ-ын хувь хэмжээ, 2015 оны 12 сарын байдлаар)


Д/д	Улс	Татварын хувь хэмжээ			
		Сүүлийн	Өмнөх	Хамгийн өндөр	Хамгийн бага
1	АНУ	39.6	39.6	39.6	35.0
2	Евро бүс	42.1	42.3	49.0	38.8
3	Хятад	45.0	45.0	45.0	45.0
4	Япон	50.84	50.84	50.84	50.0
5	Герман	47.5	47.5	57.0	44.3
6	Их Британи	45.0	45.0	50.0	40.0
7	Франц	50.3	50.3	59.6	45.4
8	Энэтхэг	35.54	34.61	35.54	30.0
9	Итали	48.9	47.9	51.0	44.1
10	Бразил	27.5	27.5	27.5	27.5
11	Канад	29.0	29.0	29.0	29.0
12	Өмнөд Солонгос	38.0	38.0	38.0	35.0
13	Австрали	47.0	45.0	47.0	45.0
14	ОХУ	13.0	13.0	13.0	13.0
15	Испани	46.0	52.0	56.0	43.0
16	Мексик	35.0	30.0	35.0	28.0
17	Индонез	30.0	30.0	35.0	30.0
18	Монгол	10.0	10.0	10.0	10.0

Эх сурвалж: <http://www.tradingeconomics.com/>

Хөгжингүй орнуудад ХХОАТ нь татварын нийт орлогын 30-иас дээш хувийг эзэлж байгаа бөгөөд “Pay As You Earn (PAYE)” буюу их орлоготой бол ихийг төлөх зарчим үйлчилж байна. Тухайлбал, Их Британи улсын хувьд ХХОАТ 20 хувь байсныг 2011 оноос эхлэн 1150 фаунд болон түүнээс дээш орлоготой иргэдийн хувьд 40-50 хувь болгосон байна.

2016 оны байдлаар Дэлхийн улс орнуудын ХХОАТ-ын хувь хэмжээг тивээр авч үзвэл хамгийн өндөр нь Африк, Америк тивийн улс байгаа бол хамгийн бага нь буюу татвар ногдуулдаггүй улсын 7 нь Ази тивд, 3 нь Америк тивд байна.

Зураг 2.1: ХХОАТ-ын дундаж хувь хэмжээ (тивээр)



Эх сурвалж: <http://www.tradingeconomics.com/>

ХХОАТ-ын дундаж хувь хэмжээг тивээр нь авч үзвэл, Америк 27 хувь, Европ 33 хувь, Ази 21 хувь, Австрали 34 хувь, Африк тивийнх 32 хувь байгаагаас харахад Ази тив харьцангуй бага хувь хэмжээтэй байна. Мөн Америк тивийн Гватемаль улсын ХХОАТ-ын хувь хэмжээ 7 хувь, Европ тивийн Монтенегро улсад 9 хувь байгаа нь улсуудын хувьд хамгийн бага үзүүлэлт болж байна. Ер нь хөгжиж байгаа улс орнуудад ХХОАТ харьцангуй бага, тогтвортой байдаг бөгөөд бараг бүхэлдээ цалин, хөдөлмөрийн хөлсөнд ногдож байна. Гэхдээ эдгээр орны тухайд ХХОАТ 1980-аад оны эхээр ДНБ-ний 1-3 хувийг эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд 9-11 хувь болтлоо өссөн байна (Peter, Buttrick, & Duncan, 2010). Хөгжиж байгаа улс орнуудын хувьд ХХОАТ-ын хувь хэмжээг бууруулж, шатлалыг багасгасан ч мэдэгдэхүйц нөлөө бага байдаг бөгөөд цөөн тооны өндөр орлоготой татвар төлөгчдөд чиглэсэн босго тавих нь орлогын алдагдлыг бууруулах ач холбогдолтой байж болох талтай (IMF, 2010) гэж үздэг. Гэхдээ татварын хувь хэмжээг өсгөх нь тийм ч таатай зүйл биш бөгөөд тухайлбал, Кени улсад 2012 оноос ХХОАТ-ыг 30 хувь болгоход татвар цуглуулах ажлын ачаалал нэмэгдсэн боловч татвар цуглуулах, хуулийг дагаж мөрдөх үр дүн муу байсан байна (IMF, 2010).

Манай хөрш ОХУ-ын оршин суугч иргэний хувьд ХХОАТ 2000-2016 оны хооронд тогтмол 13 хувь байгаа ба хүүний орлого болон шагнал урамшуулалд 30 хувиар татвар ногдуулдаг байна (Trading Economics, 2016). Мөн өмнө нь 9 хувиар ногдуулдаг байсан ногдол ашгийн орлогод 2015 оны 1 сарын 1-нээс эхлэн 13 хувиар татвар ногдуулах болжээ. Харин оршин суугч бус иргэний хувьд ногдол ашгийн орлогод 15 хувь, ОХУ-аас олсон бусад бүх төрлийн орлогод тогтмол 30 хувиар ХХОАТ ногдуулж байна (PWC, 2016). БНХАУ-ын хувьд ХХОАТ-ын суурь нь 2003-2016 оны хооронд 45 хувь байгаа ба өсөн нэмэгдэх шатлалаар 3 түвшинд 20-40 хүртэл хувиар болон үндсэн ажилтны хувьд 3-45 хувь хүртэл 7 шатлалаар татвар ногдуулах загвар ашиглаж байна. Мөн орон нутгийн хувьд сарын 3500 юань хүртэлх цалингийн орлого, гадаадад суурин амьдрагсдын хувьд сарын 4800 юань хүртэлх цалингийн орлогыг тус тус ХХОАТ-аас чөлөөлдөг байна (Hoffmann, 2015). Дээрх хоёр улсын хувьд адилхан хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, хүү болон ногдол ашигт ХХОАТ-ыг ногдуулдаг бөгөөд уг татвар засгийн газрынх нь үндсэн орлого болдог байна (Trading Economics, 2016).

3. Монгол Улсын ХХОАТ-ын шинэчлэл, хэрэгжилт

Монгол Улсад 1993 оноос мөрдсөн татварын багц хуулийн нэг нь ХХОАТ-ын хууль байсан бөгөөд түүнд өнөөг хүртэл хэд хэдэн удаагийн өөрчлөлт оржээ. 2006 онд бодлогын чанартай, томоохон шинэчлэл хийсэн бөгөөд хувь хүний жилийн орлогод 15-30 хувь хүртэл өсөн нэмэгдэх шатлалаар ногдуулж байсан татварын хэмжээг нийтэд нь 10 хувиар ногдуулахаар болсон нь татварын бааз суурийг өргөтгөх чухал алхам болсон

гэж үздэг. Энэ шинэчлэлийн гол зорилго нь шударга, үр ашигтай, энгийн байх зарчмыг хангаж, татварын ачааллыг жигдрүүлснээр хувь хүмүүсийн орлого, хөрөнгөө нуух явдлыг бууруулж, татвараа тайлагнах, төлөх үйл явц сайжирч, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж (Ч.Цэндмаа, 2012) байв.

Татварын хуулийн өөрчлөлтийн үр нөлөөг ХХОАТ-ын орлогын ДНБ болон татварын нийт орлого (ТНО)-д эзлэх хувийн жингээс харах боломжтой.

Хүснэгт 3.1: ХХОАТ-ын ДНБ, татварын нийт орлогод эзлэх хувь хэмжээ

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
ДНБ-д эзлэх хувь хэмжээ	2.6	2.4	1.8	1.94	2.16	1.65	1.75	2.08	2.34	2.17
ТНО-д эзлэх хувь хэмжээ	8.4	11.8	7.2	10.2	14.2	5.99	6.34	8.25	8.85	9.16

Эх сурвалж: Ч.Энхбаяр, 2015

Хүснэгт 2-оос ХХОАТ-ын орлого нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхүйц түвшинд хүрээгүйг харж болно. Гэхдээ ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх сонирхолтой иргэдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаатай

холбоотой ХХОАТ-ын төлөлт жилээс жилд дээшилж байна. ХХОАТ-ын хуулийн хүрээнд хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой гарсан өөрчлөлтийн талаар улс орны хэмжээнд шийдвэрлэсэн бодлого, зорилгыг авч үзье.

Хүснэгт 3.2: ХХОАТ-ын хөнгөлөлтийн өөрчлөлт

Он	Хуулийн заалт	Зорилго
1997	Монгол Улс дахь дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллага болон бусад Олон улсын байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэний орлого	Гадаад харилцааг дэмжих
	Энэ хэсгийн 10 дахь заалтад заасан ажилтан болон түүний гэр бүлийн гишүүдийн гадаад дахь эх үүсвэрээс олсон орлого	Монгол дахь валютын урсгалыг нэмэгдүүлэх
	Иргэд өөрсдийн орлого болон банкнаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар хувьдаа орон сууцны барилга барих, худалдан авахад зориулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогыг зөвхөн тухайн жилийн татвар ногдуулах орлогоос (ТНО) хасч хөнгөлөлт үзүүлэх	Иргэдийг орон сууцжуулах
	Их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөрийн төлсөн дүнг, дотоодын тухайн мэргэжлийн сургуулийн сургалтын төлбөрийн жишгээр бодон, иргэний тухайн жилийн ТНО-оос хасч, хөнгөлөлт үзүүлнэ.	Боловсролыг дэмжих
	ХХОАТ-ын хуулийн 7 зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод ногдох жилийн татвараас 36000 төгрөгөөр хөнгөлөх	Иргэдийн амьжиргааг дэмжих
	Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч Монгол улсын байнгын оршин суугчийн зөвхөн дээрх үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлөх	ХАА-н салбарыг дэмжих
2001	ХХОАТ-ын хуулийн 7 зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод ногдох жилийн татвараас 48000 төгрөгөөр хөнгөлөх	Иргэдийн амьжиргааг дэмжих
2006	ХХОАТ-ын хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн татвараас 84000 төгрөг хөнгөлөх	Иргэдийн амьжиргааг дэмжих
2009	Малчин өрхийн гишүүний тоогоор тус бүр 20 хонийг тухайн өрхөд ногдуулах албан татвараас чөлөөлөхийг хүчингүй болсонд тооцох	Төсвийн суурийг өргөтгөх
	Малчин өрх өөрийн зардлаар худаг гаргаж ашиглалтанд оруулсан бол түүнд зарцуулсан баримтаар нотлогдсон зардлыг тус хуулийн 23.3-т зааснаар тухайн жилд ногдуулсан албан татвартай тэнцэх хэмжээний хөнгөлөлтийг хүчингүй болгосонд тооцох	Төсвийн суурийг өргөтгөх

Эх сурвалж: Ч.Энхбаяр, 2015

ХХОАТ-ын хөнгөлөлтийн хувьд 1997-2009 оны хооронд гадаад харилцааг дэмжих, Монгол Улс дахь валютын урсгалыг нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцжуулах, боловсролыг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ХАА-н салбарыг дэмжих, төсвийн суурийг өргөтгөх чиглэлээр дээрх өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал, хувь хүний тухайн нэг сарын цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар НДШ тооцон хассан дүнд ХХОАТ-ыг 10 хувиар ногдуулж, гарсан дүнгээс 7000 төгрөгийн татварыг хөнгөлөх болсон.


ХХОАТ-ын чөлөөлөлтийн хувьд 1997-2015 оны хооронд иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аюулгүй байдал, нийгмийн хамгааллыг дэмжих, мал бүхий иргэдийг дэмжих, даатгал болон эрсдэлийн хамгааллыг дээшлүүлэх, хувь хүний орлого болон банкны депозитыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, НӨАТ-ын хуулийн хэрэгжилт болон хувь хүний орлогын өсөлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр өөрчлөлтүүд гарчээ.

ХХОАТ-ын хувь хэмжээний тухайд 1992-2006 оны хооронд цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 40 хувиас эхлээд 10 хувь хүртэл өөрчлөлт орсон ба 1992-1994 он хүртэл 40 хувиар, 1994-1997 он хүртэл 2 хувиас эхлээд 40 хувь хүртэл өсөн нэмэгдэх 5 шатлалаар, 1997 оноос 10, 20, 40 хувь гэсэн 3 шатлалаар, 2006 оноос одоог хүртэл 10 хувиар тус тус татвар ногдуулах болжээ. Гэхдээ иргэдийн орлогын эрс ялгаатай байдал нэмэгдэх хандлагатай болж буй нь 10 хувь гэсэн нэгдсэн хувь хэмжээг эргэн харах шаардлагатай болсныг харуулж байна.

4. ХХОАТ-ын орон нутгийн санхүүгийн чадавхид үзүүлэх нөлөө

Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал, санхүүгийн чадавхыг тодорхойлох нэг шалгуур үзүүлэлт нь орон нутгийн өөрийн орлого болон түүнд эзлэх төсвийн нийт орлого, нийт зардал (Ritonga, 2014) юм.

Зураг 4.1: Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын үзүүлэлт (сая.төг)




Эх сурвалж: www.1212.mn

Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлох зорилгоор орон нутгийн өөрийн орлого (ДНБ-ээр төлөөлүүлэн) болон орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагын 2000-2015 оны хоорондох тоон мэдээллийг нийт орон нутгийн түвшинд авч үзэхэд, төсвийн орлого 48.8 хувийн, төсвийн зарлага 48.9 хувийн хамааралтай байлаа (Зураг 4.1). Харин төсвийн орлогыг бүрдүүлдэг үндсэн эх үүсвэр болох татварын орлогын хувьд 97.9 хувийн, тэр дундаа ХХОАТ 99,1 хувийн хүчтэй хамааралтай байгаа нь татварын орлогоос

орон нутгийн санхүүгийн бие даасан байдал бүрэн хамаардаг болохыг илтгэж байна.

Монгол Улсын орон нутгийн төсвийн нийт орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрддэг бөгөөд урсгал орлого нь татварын болон татварын бус орлогоос, тусламжийн орлого нь улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогоос бүрдэж байна.

Зураг 4.2: Орон нутгийн төсвийн орлогын бүтэц (сая.төг)



Эх сурвалж: www.1212.mn; www.mta.mn

Нийт орон нутгийн төсвийн орлогын бүтэцэд татварын орлого дунджаар 86 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд 2009 оноос эхлэн тэрхүү татварын орлогын 60 орчим хувийг ХХОАТ бүрдүүлж байгаа нь орон нутгийн төсөвт ХХОАТ зонхилох ач холбогдолтой болохыг (Хүснэгт 4.1) харуулж байна.

Хүснэгт 4.1: Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар


Д/д	Төсвийн орлого	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
	Нийт орлого	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
1	Урсгал орлого	86.7	90.6	90.8	83.6	84.6	94.2	92.8	92.9	80.5	40.6	40.1	27.8
1.1	Татварын орлого	80.6	83.7	85.9	85.1	87.8	88.8	90.1	86.3	88.2	87.6	85.4	87.8
	ХХОАТ	16.6	17.6	18.5	11.0	9.9	54.1	53.3	49.9	56.9	66.4	66.8	65.1
1.2	Татварын бус орлого	19.4	16.3	14.1	14.9	12.2	11.2	9.9	13.7	11.8	12.4	14.6	12.2
2	Хөрөнгийн орлого	1.2	1.3	1.7	1.7	1.6	1.0	1.6	2.0	1.8	0.2	0.1	0.04
3	Тусламжийн орлого	12.1	8.1	7.5	14.7	13.8	4.8	5.6	5.1	17.7	59.2	59.8	72.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Эдийн засгийн идэвхтэй хүн ам болон нийт ажиллагсдын тоотой харьцуулахад цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос татвар төлөгчийн тоо бага байгаа хэдий ч Суутган 1 тайлангаар бүртгэлтэй ХХОАТ төлөгчийн тоо болон төлсөн татварын орлогын хэмжээ нь сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр нэмэгдэж байгаа бөгөөд ХХОАТ-ын 90 орчим хувийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлого бүрдүүлж байна (Зураг 4.3). Энэ нь улс орны эдийн засгийн байдал, татварын бааз

суурь өргөжиж байгааг илтгэхээс гадна 2006 оны татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар цалингийн шатлалгүй болгож, 10 хувиар цалингаас шууд хувилж авдаг, тооцоход хялбар, ойлгомжтой болсон зэрэг нь эерэг нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна. Тиймээс орон нутгийн төсвийн орлого тэр дундаа татварын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг ХХОАТ-ын орлогын тухайн орон нутгийн санхүүгийн чадавхад үзүүлэх нөлөөг тодорхойлох нь чухал байна.

Зураг 4.3: Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагсад: үүнээс ХХОАТ (Суутган-1) төлөгчийн тоо болон татвар төлөлтийн орлогын хэмжээ



Эх сурвалж: www.1212.mn; www.mta.mn

Судалгааны үр дүнгээс харахад Хөвсгөл аймгаас бусад бүх аймгуудын хувьд R-squared буюу детерминацийн коэффициент, тодруулбал, Орхон, Өмнөговь аймагт 70 хувиас дээш, Төв аймагт 80 хувиас дээш, бусад бүх аймгуудын хувьд 90 хувиас дээш буюу тухайн орон нутгийн татварын орлого нь дотоодын нийт бүтээгдэхүүнд нь

маш хүчтэй нөлөөлж байгаа нь харагдаж байна. Мөн Дорноговь, Увс, Төв, Говьсүмбэр, Дорнод аймгийн хувьд ХХОАТ-ын орлогын t statistic-ийн магадлал (prob) нь 0,05-аас бага байгаагаас харвал тухайн татварын орлого нь орон нутгийн санхүүгийн чадавхад хүчтэй нөлөөлж байгааг илтгэж байна.

Хүснэгт 4.2: Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал болон ХХОАТ, бусад хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээ

	1	2	3	4	5	6	7	8	9
1	1								
2	0.48886	1							
3	0.489503	0.997315	1						
4	0.979866	0.610832	0.611723	1					
5	0.991604	0.487935	0.488618	0.981541	1				
6	-0.053517	-0.15462	-0.15776	-0.09146	-0.10306	1			
7	0.991143	0.511731	0.512494	0.980677	0.987782	-0.05845	1		
8	0.810397	0.302143	0.303026	0.784629	0.791303	-0.01363	0.83555	1	
9	0.820896	0.309929	0.310983	0.794664	0.801141	-0.01474	0.844055	0.998928	1

Тайлбар:
 Дотоодын нийт бүтээгдэхүүн /сая. төгрөг/
 Төсвийн орлого /сая. төгрөг/
 Төсвийн зардал /сая. төгрөг/
 Татварын орлого /сая.төгрөг/
 Хувь хүний орлогын албан татварын хэмжээ /сая. төгрөг/
 Инфляцийн түвшин
 Татвар төлөгчийн тоо
 15-аас дээш насны ажиллагсдын тоо
 Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо

Орон нутгийн санхүүгийн чадавх нь инфляцийн түвшнээс бусад үзүүлэлттэй шууд хүчтэй хамааралтай гарсан бол инфляцийн түвшинтэй урвуу сул хамааралтай гарсан байна. Инфляци нэмэгдэх хэрээр орлого

буурах нь ойлгомжтой. Хамгийн гол нь орон нутгийн санхүүгийн чадавхад татварын орлого, тэр дундаа ХХОАТ маш хүчтэй хамааралтай байна. Магадгүй энэ нь хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн

амд эзлэх хувь өссөн, өөрөөр хэлбэл, “Хүн амын цонх” үе тохиож байгаа нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн байж болох талтай. Нөгөөтэйгүүр татварын орлогын өсөлт нь ДНБ-ний орлогын өсөлтийг бий болгож чадаж байгаа, орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг дээшлүүлж буйг харуулж байна.

5. Дүгнэлт

ХХОАТ-ын хувь хэмжээ, шатлал нь эдийн засгийн хөгжлөөс ихээхэн хамаарч байна. Хөгжиж байгаа улс орнуудад ХХОАТ харьцангуй бага, тогтвортой байдаг бол хөгжингүй улс орнуудад “Pay As You Earn (PAYE)” буюу их орлоготой бол ихийг төлөх зарчим үйлчилж байна. Манай 2 хөршийн хувьд ОХУ-ын ХХОАТ 2004-2016 оны хооронд тогтмол 13 хувь, хүүний орлого болон шагнал урамшуулалд 30 хувиар татвар ногдуулж байгаа бол БНХАУ-ын ХХОАТ-ын суурь нь 2003-2016 оны хооронд 45 хувь байгаа ба өсөн нэмэгдэх шатлалаар 3 түвшинд 20-40 хүртэл хувиар, үндсэн ажилтны хувьд 3-45 хувь хүртэл 7 шатлалаар татвар ногдуулж байна. Монгол Улсад 1992 оноос ХХОАТ-ын хуулийг анхлан боловсруулж мөрдсөнөөс хойш өнөөг хүртэл хэд хэдэн удаагийн өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн ба бодлогын чанартай хамгийн томоохон шинэчлэл нь 2006 оны хуулийн шинэчилсэн найруулга болжээ. Энэ шинэчлэлээр татварын суурийг өргөтгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтмол 10 хувиар ногдуулах болсны үр дүнд татварын тогтолцоонд шударга, үр ашигтай, энгийн байх зарчим биеллээ олж, хувь хүмүүсийн орлого, хөрөнгөө нуух явдал буурч, татвараа тайлагнах, төлөх үйл явц жилээс жилд сайжирч байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам болон нийт ажиллагсдын тоотой харьцуулахад ХХОАТ төлөгчийн тоо харьцангуй бага байгаа ч ХХОАТ-ын өсөлтийн хувь жилээс жилд эерэг үзүүлэлттэй байгаа бөгөөд 2007 онд сөрөг үр дүн гарсныг эс тооцвол ерөнхийдөө тогтмол өсөлттэй байна. Орон нутгийн санхүүгийн чадавхыг ДНБ-ээр төлөөлүүлэн авч үзэхэд, 21 аймгийн ДНБ болон татварын орлого, ХХОАТ нь хоорондоо хүчтэй хамааралтай, орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлогч гол үзүүлэлт болох нь харагдлаа. ХХОАТ-ын орлого нэмэгдэх нь орон нутгийн санхүүгийн чадавх дээшлэх,

энэ нь эргээд татварын орлого нэмэгдэх шалтгаан болж байгаа бол харин инфляцийн түвшин өсөх нь татварын орлого буурах шалтгаан болж байна.

Ашигласан материал

- Cottarelli.C, (2011). Revenue Mobilization in Developing Countries. *International Monetary Fund*, 4-5.
- Arnold.J, (2008). *Do Tax Structures Affect Aggregate Economic Growth? Empirical Evidence from a Panel of OECD Countries*. Paris: Organization for Economic Cooperation and Development.
- Hoffmann.R, (2015, 03 31). *Focus China*. Retrieved from ECOVIS Beijing China.
- IMF, (2010). Reaching the MDGs: Macroeconomic Prospects and Challenges in Low-Income Countries. *Background Note for the United Nations MDG Summit*. International Monetary Fund.
- Peter.K.S., Buttrick.S.,& Duncan.D, (2010). Global Reform of Personal Income Taxation, 1981-2005: Evidence from 189 countries. *National Tax Journal*, 63, 447-478.
- PWC, (2016). *Worldwide Tax summaries*.
- Ritonga.I.T, (2014). *Modelling local government financial conditions in Indonesia*. Melbourne, Australia.
- Rosen.H. S., & Gayer.T, (2013). *Public Finance, Tenth edition*. United States.
- Trading Economics, (2016). *Trading Economics*.
- United Nations. (2005). *Investing in Development*
- Ч.Цэндмаа, (2012). *Хувь хүний орлогын албан татварыг боловсронгуй болгох нь*. Татварын ерөнхий газар, Улаанбаатар
- Ч.Энхбаяр, (2015). *Хувь хүний орлогын албан татварын хуулийн өөрчлөлтийн хэрэгжилт*. Улаанбаатар